



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 107

Улаанбаатар хот

Г “ЯАХ” хоршооны хадгаламж, зээлийн г
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг
хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, 14.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “ЯАХ” хоршооны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2010 оны 4 дүгээр сарын 05-ны өдрөөс хүчингүй болгосугай.

2. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан хоршоог холбогдох хууль тогтоомжийн дагуу татан буулгах, шаардлагатай гэж үзвэл татан буулгах комисс томилон ажиллуулж, өр төлбөрийг зохих журмын дагуу бүрэн барагдуулж, Улсын бүртгэлээс хасуулах арга хэмжээ авахыг “ЯАХ” хоршоо /Б.Энхсайхан/-нд үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН